



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ”-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор барилгын гадна дулааны шугам сүлжээний ажлын хүрээнд бий болсон нийт 1,638,115,053.00 (нэг тэрбум зургаан зуун гучин найман сая нэг зуун арван таван мянга тавин гурван) төгрөгийн үнэлгээ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дарга М.Баяраа, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Б.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001549

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн
277... дугаар тогтоолын хавсралт

**"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ	Нийт балансын үнэ
				Төгрөгөөр	
1	Ф400 шугам /хавтангаар хучигдсан төмөр бетон сувагтай/	Ф400	2,263	588,135.00	1,330,949,505.00
2	Дулааны худал	0	8	21,612,483.00	172,899,864.00
3	Сильфон компенсатор	Ф426	24	1,860,000.00	44,640,000.00
4	Бөмбөлгөн хаалт	Ф32	2	140,000.00	280,000.00
5	Бөмбөлгөн хаалт	Ф400	4	162,000.00	648,000.00
6	Бөмбөлгөн хаалт	Ф125	4	320,000.00	1,280,000.00
7	Бөмбөлгөн хаалт	Ф100	2	450,000.00	900,000.00
8	Бөмбөлгөн хаалт	Ф150	4	2,189,361.00	8,757,444.00
9	Бөмбөлгөн хаалт	Ф200	4	3,850,000.00	15,400,000.00
10	Бөмбөлгөн хаалт	Ф400	4	15,432,560.00	61,730,240.00
11	Ган чиг өөрчлөгч	Ф125	1	30,000.00	30,000.00
12	Ган чиг өөрчлөгч	Ф150	4	50,000.00	200,000.00
13	Ган чиг өөрчлөгч	Ф200	4	100,000.00	400,000.00
Нийт дүн:					1,638,115,053.00
					(нэг тэрбум зургаан зуун гучин найман сая нэг зуун арван таван мянга тавин гурван)